



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/201

Улаанбаатар хот

Үндэсний их баяр наадмаар ажиллах  
хуваарь батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйл, 78.2, 78.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх” журмын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тулгар төрийн 2228, Их Монгол Улсын 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тохижилт, засвар, хог хаягдал цэвэрлэгээ, худалдаа үйлчилгээ, цахилгаан хангамжийн ажлын батлагдсан хуваарьт хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т, Хүнс худалдаа, үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэчимэг/-т, Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/-т тус тус даалгасугай.

2. Үндэсний их баяр наадмын бэлтгэл арга хэмжээний үеэр батлагдсан хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах албан хаагчдын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

3. Үндэсний их баяр наадмын баярын өдрүүдэд ажилласан албан хаагчдыг нөхөж амрах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

